



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/288

Булган сум

┌ Инженер геологийн судалгааны гэрээ ┐
байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 35 дугаар зүйлийн 35.1.2, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоолын хавсралтын 2 дугаар заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2014 оны 56 дугаар тушаалаар баталсан “Барилгын инженер геологийн ажлын жишиг үнэ БД 81-117-13” нормыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Булган аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрт тусгагдсан бүтээн байгуулалтын ажлуудын зураг төслийн өмнөх инженер геологийн судалгааны ажлын байршлуудын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Инженер геологийн судалгаа хийхээр үнийн санал ирүүлсэн “Лэнд Тэст” ХХК-тай нийт 11,048,400 (арван нэн сая дөчин найман мянга дөрвөн зуу) төгрөгт багтаан гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

3. Инженер геологийн судалгааны ажлын явцад байнгын хяналт тавьж магадлалаар хянагдсан инженер геологийн судалгааны тайланг хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4. Хавсралтад тусгасан ажлын санхүүжилтийг тухайн төсөл арга хэмжээний батлагдсан төсвөөс гэрээнд заасан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010277

Аймгийн Засаг даргын 2023 оны
04 дүгээр сарын 21-ны өдрийн А/28
дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН
СУДАЛГАА ХИЙХ БАЙРШЛУУДЫН ЖАГСААЛТ

№	Сумын нэр	Барилгын нэр	Геологийн судалгааны үнэ
1	Хангал	Хялганат тосгоны соёлын төвийн барилга	3,462,800
2	Могод	Спорт заал	3,902,800
3	Хутаг-Өндөр	500тн механикжсан зоорийн барилга	3,682,800
Дүн			11,048,400

---oooOOOooo---